



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот

М.Отгонбаярт сахилгын  
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.13, 37.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.2 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.8 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, 10.4, 10.5, 10.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Мижиддоржийн Отгонбаяр нь холбогдох хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж ажиллаагүй нь Хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2024 оны 980 дугаар дүгнэлт болон өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс нээлттэй сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Отгонбаярт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/- т үүрэг болгосугай.

3. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142400874